



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2018 оны 5 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар  
хот

Газрын шинэтгэлийн үндэсний хорооны  
бүрэлдэхүүн батлах тухай

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан “Газрын шинэтгэлийн үндэсний хороо”-ны бүрэлдэхүүнийг дор дурдсанаар өөрчлөн баталсугай:

- |                      |  |
|----------------------|--|
| Орлогч дарга         | -Барилга, хот байгуулалтын сайд.   |
| Гишүүд:              | -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;<br>-Батлан хамгаалахын сайд;<br>-Гадаад харилцааны сайд;<br>-Сангийн сайд;<br>-Хууль зүй, дотоод хэргийн сайд;<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;<br>-Зам, тээврийн хөгжлийн сайд;<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;<br>-Эрчим хүчний сайд;<br>-Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;<br>-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга;<br>-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;<br>-Нийслэлийн Засаг дарга. |
| Нарийн бичгийн дарга | -Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга.  |

2. Газрын шинэтгэлийн үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.


3. Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 2018 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан Үндэсний хорооны хуралдаанд 2018 оны 5 дугаар сард багтаан танилцуулахыг Үндэсний хорооны Ажлын албанд үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” Ерөнхий сайдын 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 82 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ



Ерөнхий сайдын 2018 оны 98 дугаар захирамжийн хавсралт

## ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Газрын шинэтгэлийн Үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх) нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын шинэтгэлийн чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө болон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Үндэсний хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Үндэсний хорооны удирдлага, бүтэц, зохион байгуулалт

2.1. Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

2.2. Үндэсний хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тогтоол, тэмдэглэл, зөвлөмж гаргана. Үндэсний хорооны тогтоолд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.3. Үндэсний хорооноос гаргасан тогтоол, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлт, үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд Үндэсний хорооны Ажлын албанд хүргүүлнэ.

2.4. Үндэсний хорооны хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулж, газрын шинэтгэлийн чиглэлээр Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүн, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэнэ.

2.5. Хуралдааны дэгийг Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэн батлах бөгөөд Үндэсний хорооны даргын түр эзгүйд хорооны орлогч дарга, эсхүл хорооны даргын томилсон аль нэг гишүүн хуралдааныг даргална.

2.6. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Үндэсний хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдаанаас гарсан шийдвэрийг яам, холбогдох газруудад хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавьж, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг хариуцна.

## Гурав. Үндэсний хорооны эрх, үүрэг

### 3.1. Үндэсний хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Газрын шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, энэ талаарх хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, салбар хоорондын уялдаа зохицуулалтыг хангах;

3.1.2. Газрын нэгдмэл сангийн ашиглалт, хамгаалалтыг боловсронгуй болгох, мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.1.3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Газрын шинэтгэлтэй холбоотой өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах асуудлаар олон улсын болон үндэсний чанартай хурал, зөвлөгөөн, семинар, ярилцлага зохион байгуулах;

3.1.5. Үндэсний хорооны шийдвэр, зөвлөмжийн биелэлт, мэдээ, материалыг холбогдох газраас гаргуулан авах, түүнд зохих санал дүгнэлт өгөх;

3.1.6. Үндэсний хорооны үйл ажиллагаа, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд сурталчлах;

3.1.7. Үндэсний хорооны шийдвэр, зөвлөмжийг биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд албан ёсоор анхааруулга өгч, шаардлага тавих.

### Дөрөв. Үндэсний хорооны ажлын алба

4.1. Үндэсний хороо нь өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах Ажлын албатай байна.

4.2. Ажлын албаны чиг үүргийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх бөгөөд Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дарга байна.

### Тав. Бусад зүйл

5.1. Үндэсний хороо нь үйл ажиллагаагаа хуралдаанаар хэлэлцэн баталсан жил бүрийн ажлын төлөвлөгөөний дагуу явуулна.

5.2. Үндэсний хорооны үйл ажиллагааны жилийн тайланг жил бүрийн I улиралд багтаан Үндэсний хорооны дарга болон гишүүдэд танилцуулж, Засгийн газарт албан бичгээр хүргүүлж тайлагнана.